



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

АДАН. 07.20 № 124

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭРЭН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Дэрэн сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Дэрэн сумын Монгол ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Дэрэн сумын Монгол ардын намын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


0012020227

Дэрэн сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр / 3. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дэрэн сумын сонгуулийн хороонд

Хавсралт . . 3. . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Handwritten signature of P. Tövsanaa in cursive script, overlaid on a faint rectangular stamp.

П.ТӨВСАНАА



БАТЛАВ.
Дэрэн сумын МАН-ын хорооны
тэргүүлэгчдийн 2020 оны 06-р сарын 17-
ны өдрийн хурлын шийдвэрээр батлав

АСУУДЛЫГ ШИЙДҮҮЛЖ АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛНА

Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны ээлжит сонгуулийн
Дундговь аймгийн Дэрэн сумын Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр

Төрийн үйлчилгээг иргэдэд оновчтой зохион байгуулж, иргэдэд тэгш хүргэж хүний хөгжлийн бодлогыг орон нутагт бүрэн хэрэгжүүлж ажиллах

-Өрхийн бичил бизнесийг дэмжиж санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх бодлогыг
хэрэгжүүлж ажиллана.

-Иргэдийн ажлын туршлага ур чадварт тулгуурлан тэднийг хувиараа хөдөлмөр
эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж хөнгөлттэй зээл олгоход дэмжиж ажиллана.

-Орон сууцжуулах зорилтын хүрээнд орон сууц барих ажлыг зохион байгуулна.


-Иргэн бүрийг эрүүл мэндийн оношилгоонд жил бүр заавал хамрагдуулах арга
хэмжээг авч хэрэгжүүлэх.

Сумын хүний нөөцийн бодлого ялангуяа эрүүл мэнд, боловсрол орон нутгийн төрийн байгууллагад боловсон хүчин бэлтгэхэд бодлого боловсруулж ажиллах

-Багш, эмч, төрийн албан хаагчдын мэргэжил, мэргэшил, ур чадварыг
дээшлүүлэхэд гадаад дотоодын сургалт үйл ажиллагаанд тасралтгүй хамруулж
аливаа хөтөлбөр арга хэмжээнд хамруулна.

-Сумын эрүүл мэндийн төвийг эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр
хангаж бүрэн ашиглаж хүртээмжийг сайжруулах.

-Сумын сургууль, цэцэрлэгийн тохижилт стандартыг хангаж суралцагсдын
орчинг бүрдүүлэхэд анхаарч танхимуудын тохижилтыг хийх.


-Хичээлээс гадуурхи суралцагсдын авъяас чадварыг хөгжүүлэх секц дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлэх ялангуяа хөдөлмөрт бэлтгэх кабенит байгуулах ажлыг дэмжиж ажиллах.

-Орлого багатай зорилтот бүлгийн өрхүүдийг олон нийтийн оролцоонд түшиглэн халамж болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулж амьжиргааг дэмжиж ажиллах.

-Хүүхдийн эрх хөгжил хамгаалал, осол гэмтэл, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах эрхзүйн тогтолцоог орон нутагт хэрэгжүүлж ажиллах

-Залуучуудын амьдрах ажиллах нөхцөл чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх нөхцлийг бүрдүүлэх, санал санаачлагыг дэмжиж ажиллах, тэдний эрүүл мэнд боловсрол хөдөлмөр эрхлэлт тэднийг дэмжсэн бүхий л хөтөлбөр арга хэмжээнд хамруулж ажиллана.

-Тусгай хэрэгцээт иргэдэд төрөөс үзүүлж буй бүхий л хөтөлбөр арга хэмжээнд хамруулж ажиллана.

-Ахмад настнуудад үзүүлэх төрийн үйлчилгээнд бүрэн хамруулж тэдний чөлөөт цагийг өнгөрөөх төв байгуулж тэдний мэдлэг туршлагыг өвлөн авч үлдээхэд анхаарч зөвлөх багийг ажиллуулах.

-Сумын түүх дурсгалын газрыг хамгаалах соёлын өвийг дэлгэрүүлэх алдар цуутай иргэдээ алдаршуулах, иргэд олон нийтийн оролцоо үндэсний соёл спортыг сурталчлах таниулахад санаачлагатай оролцох нөхцлийг бүрдүүлж ажиллах.

Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж бүтээн байгуулалтыг хийж тохилог орчин амьдрах нөхцлийг бүрдүүлэх

-Шинэ сум төсөлд хамрагдах.

-Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж шинээр орон сууц барих

-Ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, хуучин талбайн хашаанд засвар хийж мод жимсний модны ургалтыг сайжруулж чацарганы талбайг иргэдэд түрээслүүлэх.

-Сумын төвийн хогийн цэгийн менежментийг сайжруулж, хашаажуулна.

-Сумын нийтлэг үйлчилгээний төв байрыг шинээр барьж эрүүл мэндийн төвийн байранд их засвар өргөтгөл хийх.

-Ахмад залуучуудын өргөөтэй болох.



- Нийтийн ахуй үйлчилгээний нэгдсэн байрыг барьж ашиглалтанд оруулах
- Цэцэрлэгийн байранд их засвар хийж орчин нөхцлийг сайжруулах.
- Соёлын төвийн байранд их засвар хийх
- Жил бүр алслагдсан бэлчээрт инженерийн хийцтэй гүн өрмийн болон энгийн уурхайн худаг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг зохион байгуулна.
- Малын тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлнэ
- Малын гаралтай түүхий эд, арьс шир түүхий эд боловсруулах жижиг оврын үйлдвэр, сүү сүүн бүтээгдхүүний боловсруулалтыг дэмжиж ажиллана.
- Малчид бүлгээрээ бүтээгдхүүнээ зах зээлд зохион байгуулалттайгаар борлуулах тогтвортой системийг бий болгоно.
- Өрхийн хэмжээнд төрөл бүрийн ногоо тариалах, өвөл зудын хүлэмжийн аж ахуйг дэмжиж ажиллана.
- Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах малчдад үйлчлэх мал эмнэлгийн нэгжийн ажлыг чанарын шинэ шатанд гаргах
- Аялал жуулчлалын баазын үйл ажиллагааг дэмиж орон нутагтай хамтран ажиллах гэрээг хийж нийгмийн хариуцлагыг хангах ажиллах
- Сум хөгжлийн сангийн үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлж үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Их дээд болон мэргэжлийн сургууль төгсөж байгаа орон нутгийн залуучуудыг нутагтаа ирж ажиллах нөхцлөөр хангана.



ДЭРЭН СУМЫН МАН-ЫН ХОРОО